

Замын-Үүд дэх Гаалийн газрын 2024 оны
 02 дугаар сарын 18-ны өдрийн
 021 дугаар албан бичгийн хавсралт
 252



**ЗАМЫН ҮҮД БООМТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭСЭГТ КОФЕ ШОПЫН ҮЙЛ
 АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ АЖЛЫН БАЙР ТҮРЭЭСЛЭГЧ СОНГОН
 ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР**

1.Түрээслүүлэгч байгууллагын нэр: МУГЕГ-ын харьяа Замын-Үүд дэх гаалийн газар

2.Түрээслүүлэх эд хөрөнгийн танилцуулга: Замын-Үүд хилийн боомтын Ачаа тээврийн шалган нэвтрүүлэх цогцолборын 1-р байрны нэгдүгээр давхарт:

- Кофе шопийн зориулалттай 46 м² ажлын байр.

3.Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 11 цаг 00 минут
Материал хүлээн авах хаяг	Дорноговь аймаг. Замын үүд сум Засаг даргын тамгын газрын Утас: 96964248. 91914277
Материал нээх хугацаа байршил хаяг	Замын-Үүд сум, 1-р баг Засаг даргын тамгын газрын 106 тоот өрөөнд 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 11 цаг 20 минут.
Эд хөрөнгө түрээслүүлэх үнийн доод хэмжээ	1м ² 2500 /Хоёр мянга таван зуун/ төгрөг. Түрээсийн үнэнд ашиглалтын зардал багтаагүй болно.
Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрлийн мэдээлэл	Замын-Үүд боомтод үйл ажиллагаа явуулах хилийн шалган нэвтрүүлэх байгууллагын зөвшөөрөл
1.Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаархи товч мэдээлэл	<p>Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49, 51 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн түрээслэгч сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод зохион байгуулна.</p> <p>Эрхэлсэн үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, санхүүгийн чадвартай гэдгээ оролцогч өөрөө нотлох зорилгоор бүрдүүлэх материалыг бүрэн ирүүлнэ. Материал дутуу тохиолдолд үл маргах журмаар хасна.</p> <p>Ажиллагсдын 50%-ийг орон нутгийн иргэдээс бүрдүүлж, зохих сургалтанд хамруулах нь давуу эрх тооцогдно.</p> <p>Материалыг бүрэн ирүүлсэн, тавигдах шаардлагыг хангасан бөгөөд түрээсийн хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн 1 (нэг) оролцогчийг шалгаруулна.</p> <p>Гэрээ байгуулах эрх олгосон аж ахуйн нэгжийн байршуулах барьцаа хөрөнгө 1 сарын түрээсийн хэмжээнээс доошгүй байна.</p>

<p>2.Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ нотариатаар баталгаажуулсан хуулбар 2. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага хангасан батламж болон зөвшөөрлийн бичиг баримт 3. 2022, 2023 оны аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан 4. Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаархи мэдээлэл 5. Санхүүгийн чадварыг нотлох баримт, сүүлийн хоёр жилийн санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын тайлангийн тодорхойлолт 6. Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, ажлын үнэмлэх, нийгмийн даатгал төлөлтийн лавлагаа. 7. Түрээслэх талбайн нэг м²-ийн талбайн түрээсийн үнийн саналыг албан бичгээр ирүүлэх 8. Түрээслэх талбайн дотоод зохион байгуулалт интерьер зураг, кофений болон бусад тоног төхөөрөмж, эд хогшлын жагсаалт, зураг, танилцуулга 9. Үйлчлүүлэгийн эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцсэн, олон нийтэд танигдсан кофе болон бусад хоол, хүнсний бүтээгдэхүүний цэс, танилцуулга, 10. Шүүхийн шийдвэрээр болон нийгмийн даатгал, татварын өргүй тодорхойлолт /emongolia-c/ 11. Хоолны газрын нийтлэг журмыг дагаж мөрдөх талаархи албан бичиг 12. Сонгон шалгаруулалтын үнийг нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл 13. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулж буй ажлын хэсгийн гишүүд болон Замын үүд дэх гаалийн газрын удирдах албан тушаалтануудтай ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн албан бичиг 14. Дээрхи материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд сонгон шалгаруулалтаас татгалзах үндэслэл болно.
---	--

Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах

Түрээслүүлэх хөрөнгийг өмч эзэмшигч Замын үүд дэх гаалийн газрын байр дээр очиж үзэж болох бөгөөд сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг 91914277, 96964248 утсаар холбогдож, мөн цахим шуудангаар авна уу.

Сонгон шалгаруулалтанд тэнцэж, гэрээ байгуулсан тохиолдолд хилийн тусгай бүсэд үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг Хил хамгаалах байгууллагаас авсан байхыг анхаарна уу.

ЗАМЫН-ҮҮД ДЭХ ГААЛИЙН ГАЗАР